

Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурлын тэмдэглэл

2015.04.24

Улаанбаатар хот.

Тус компанийн Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурал, хурал хийхээр товлосон зарын дагуу 2015.04.24 ний өдрийн 14 цагт бүртгэл эхэлж, 14 цаг 30 минутад Компанийн танхимд болов.

Хурлын дэгийн дагуу хурал эхлэхээс өмнө Тооллогын Комисс Хувьцаа Эзэмшигчдийн хурлын ирцийг бүртгэж, саналын эрхийн тоо, хурлын ирц, Тооллогын комиссын 2015.04.24 ний өдрийн "Хурал хүчин төгөлдөрт тооцох" № 01 тоот тогтоолыг уншиж танилцуулав. / уг тогтоолыг хурлын материалын ...-р хуудсанд хавсаргав /

Тооллогын комиссын гишүүн Н.Болортуяа : Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хуралд 3800721 ширхэг хувьцаа эзэмшсэн 9631 хувьцаа эзэмшигчдээс саналын эрх бүхий 2161254 ширхэг хувьцаа эзэмшсэн, 377 хувьцаа эзэмшигч ирсэн байна. Энэ нь нийт хувьцааны 56,86 % ийг төлөөлж байна. Иймээс Компанийн тухай хуулийн 69-р зүйлийн 1-д заасан заалтыг үндэслэн "Хурал хүчин төгөлдөрт тооцсугай" гэв.

Үүний дараа Хурлын дарга, тэргүүлэгчид, нарийн бичгийн даргаар хэн хэнийг сонгох саналтай байгаа талаар асуухад:

Хувьцаа эзэмшигч С.Бямбаа: Хурлын даргаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн М.Батогтохыг, тэргүүлэгчдээр Уламбаяр, Самдан нарийн бичгийн даргаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга И.Өлзийбаярыг сонгох саналтай байна гэв.

М.Батогтох : 2014 онд би Махимпэкс ХК ийн ТУЗ –ийн хараат бус гишүүнээр ажилласан, өнөөдөр дахин нэр дэвшигдэж байгаа учраас би өөрийн саналаар татгалзаж байна гэсэн учир хурлын даргыг Л. Янжинг сонгох саналыг дахин гаргав. Хувьцаа эзэмшигчид уг саналыг 100% санал нэгтэй баталж, хурлын дарга, тэргүүлэгчид, нарийн бичгийн дарга нарыг ажилдаа орохыг урив.

Хурлын дарга Л.Янжин хурлыг нээж, хуралд ирсэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүд, компанийн удирдлагуудыг танилцуулж, "Хурлын дэгээ батлах уу" гэхэд хувьцаа эзэмшигчид санал нэгтэй батлав. Өнөөдрийн хурлаар:

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны тайлан,
 2. Компанийн 2014 оны санхүүгийн үйл ажиллагааны тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
 3. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
 4. 2015 оны ТУЗ-ын төсвийг батлах
 5. Ногдол ашгийг 100 төгрөгөөр хуваарилах асуудлуудыг хэлэлцэнэ гэсний дагуу хурлын дараалаал ёсоор:
1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны тайланг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүн М.Лхачинбал
 2. Компанийн 2014 оны санхүүгийн тайланг ерөнхий нябо З.Ичинноров нар тайлагнав.

Илтгэлүүдийн дараа Нэр Дэвшүүлэх Хорооны гишүүн Жанчивдорж Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнээр нэр дэвшигчдийн товч намтарыг уншиж

танилцуулж Компанийн хуульд заасан Төлөөлөн Удирах Зөвлөлийн хараат бус гишүүн байх шаардлагыг хангасан талаар тайлбар хийв.

Хурлын дарга Л.Янжин : Одоо санал, шүүмжлэлдээ оръё.Хэнд ямар санал,шүүмжлэл байна вэ?

*Стандарт Инвест брокер диллерийн компанийг төлөөлж байгаа Чимгээ:Бидэнд тараагдсан хурлын материалд санхүүгийн үзүүлэлтүүд, баланс хэвлэгдсэн байна, нийт орлого гэж бичсэн байна, нийт орлогод ямар ямар орлогууд багтаж байгаа юм бэ? Үүнийхээ задаргааг хэлж өгнө үү?

3.Ичинноров: Манай компани махнаас 13 тэрбум төгрөг, хиамнаас 5 тэрбум төгрөг олжээ,эдгээр нь үйл ажиллагааны орлого болно. Гэрээт бус болон хадгаламжийн орлого бусад орлогод багтсан.

*Хувьцаа эзэмшигч Энхтуяа:ногдол ашгийг 2015.10.01 ээс эхлэн тараана гэжээ.маргаашнаас тарааж болдоггүй юм уу? яагаад заавал 10-р сарын 1 гэж ,нэг их ногдол ашиг өгдөг ч юм шиг.

3.Ичинноров: Компанийн санхүүгийнхээ нөхцөл байдлаас шалтгаалж 2015.10.01 ээс тараана гэсэн. Засгийн газраас хөнгөлөлттэй зэл авна, тэр мөнгө орж ирсэний дараа ногдол ашиг тараах боломжтой.Одоо нэг дор их хэмжээний бэлэн мөнгө тараах боломж арайхан алга байна.

*Хувьцаа эзэмшигч Аюуш: Тараах материалаа эртхэн тарааж баймаар байна. Ногдол ашгаа хэдийд авч болох вэ?

3.Ичинноров:ногдол ашгийг өдөр бүр ажлын цагаар 08_17 цагын хооронд өгч байгаа, ажлын альч өдрүүдэд авч болно. Хурлын материалтай танилцаж болохыг хурлын зар дээр тавьсан. Хурлын зарыг хэвлэлээр 2 удаа гаргасан, мөн Хөрөнгийн биржийн сайтад тавьсан.таны саналыг бид хүлээж авлаа.

Хувьцаа эзэмшигч Батбаяр: компанид үхмэл хөрөнгө их байна,ашиглаагүй газар их байна,ямар их үйлдвэр, цех, тасгууд байлаа, одоо байхгүй,та нар ичээч хашаан дотор байгаа барилгуудаа хараачээ, засч янзалж болдоггүй юм уу? аль эсвэл нурааж өөр шинээр барилга байгуулж барьж болдоггүй юм уу? тэгж чаддаггүй юм бол газраа түрээслээч,аль эсвэл бидэнд наад газраа хуваагаад өгчих тэгвэл бид наад газар дээр чинь өчнөөн юм барина,арай дэндүү байна, хувийнх юм байсан бол ингэхгүй шүү дээ.

Хувьцаа эзэмшигч Хорлоо:Би энэ компанийн сурталчилгааг их муу байна гэж хэлмээр байна, дэлгүүр орно, дандаа хувийн үйлдвэрүүдийн бүтээгдэхүүн дүүрэн байхад махимпэксийн бүтээгдэхүүн олддоггүй, тэгээд маш үнэтэй,тэр болгон худалдаж авч чаддаггүй,танай бүтээгдэхүүнээс идэж үзмээр байна шүү дээ, хөдөлгөөн муу байна, танай ажлыг муу гэж хэлэх гэж байна,хувийн жижиг үйлдвэрээс долоон дор байна,аль ч дэлгүүрт ороход бүтээгдэхүүн өрөөстэй байх хэрэгтэй шүү дээ.

Хувьцаа эзэмшигч Энхгэрэл:Компаниуд 2 янзын өөр өөр тайлан гаргадаг гэдэг одоо нууц биш болсон, та нар аль тайлангаа тавиад байгаа юм бэ?өчнөөн жилийн түүхтэй, ууган үйлдвэр байтлаа жилийн ашиг нь 300 сая гэхэд хүн итгэх үү? Болимоор юм.хэнийг хуурах гэсэн юм.

Хувьцаа эзэмшигч Энхтуяа:хувьцаа эзэмшигчдэд гарын бэлэг өглөө, талх, боов, гурил харагдаж байна,өөрсдийнхөө бүтээгдэхүүнийг авмаар байна.бид нар хөрөнгөө оруулчихаад бүтээгдэхүүнээ ядаж авмаар байна.Би эдийн засагч хүн та нар бид нарыг хуурахаа боливол яасан юм бэ? Одоо цагт юм ойлгодоггүй хүн бараг байхгүй болсон шүү,тайлангаа хар, хиамны борлуулалтыг л яриад байна, мах яасанюм бэ?махаа бэлдээд худалдаандаа гаргаачээ.мах нядлахаа бүр байсан.

Хувьцаа эзэмшигч Дүгэржав:Эрт ирээд бүртгүүлэх гэж хэдэн цаг болоо,эрт ирсэн хүмүүсээ хүлээн авч уулзаж, санал хүсэлтийг нь сонсож болдоггүй юм уу?гадаа хэдэн цаг зогслоо,өчнөөн олон жилийн ногдол ашиг гэж 10.000₮ л авлаа,ногдол ашиг бага байна,өөр компаниудын хувьцаа өсөөд байна, манай компанийн хувьцааны үнэ бага байна, ногдол ашиг бага болохоор хүмүүс их ногдол ашиг тараадаг компанийн хувьцааг авч үнийг нь өсгөж байна, буруу биш шүү дээ.

Хувьцаа эзэмшигч Оюунтунгалаг:Үнэт цаасны хадгаламжийн төвөөр орж ногдол ашгаа авъя гэсэн юм, тэгэхэд намайг авсан байна гэдэг, би уулнь аваагүй юм, үүнийг яаж авах вэ?

З.Ичинноров:Хэрвээ та ногдол ашгаа аваагүй бол компани дээр ирж шүүлгэж болно. Бид ногдол ашгийг өгч байгаа.

Бадарч:Би энэ үйлдвэрт 1965 оноос ажиллаж байсан, одоо тэтгэвэрт байгаа,би үйлдвэрээ хараад санаа зовж байна,унаган үйлдвэр унаж байна, та нар ажил хийхгүй байгаа юм биш үү? Бүтээдхүүний дээжээ хурлын дараа өгч баймаар байна, хуралдаа суухгүй, юм авах гэж ирдэг юм шиг байна.махны үндсэн үйлдвэрлэл ер нь байхгүй болсон юм шиг байна.

Хувьцаа эзэмшигч Ганзориг:Балансад хөрөнгө огт нэмэгдээгүй байна.Хөрөнгө оруулалт хийгээгүй байна.үл хөдлөх хөрөнгөө нэмээч,их юм хиймээр байна, бид та нараас их зүйл хийгээсэй гэж хүсч байна шүү.

Хувьцаа эзэмшигч Доржжүгдэр:Тайлан илтгэлийг сонслоо, илтгэл бүрхэг байна,мал төхөөрөхөө больсон юм уу? нядалгааны цех ажиллахгүй байна,бог бод малын.нядалгааг нэмээч,мал яагаад нядлахгүй байна вэ?

Хувьцаа эзэмшигч Пүрэвбаатар:Үйлдвэрээ үзүүлээч, нээлттэй хаалганы өдөр зохион байгуулж болдоггүй юм уу?

Стандарт Инвест БДК : Нэмэлт хувьцаа гаргаж, хөрөнгө босгоод бүтээн байгуулалт хийж болно. Хөрөнгө оруулалтандаа хэрэглээч гэдэг санал хэлмээр байна.Санхүүгийн тайлан болон ногдол ашиг хэдэн төгрөгөөр, хэдэн хүнд тараасныг сүүлийн 5 жилээр гаргавал бидэнд үзэж харж дүгнэлт гаргахад хэрэгтэй байна.Хиам Консервний үйлдвэр биеэ даасан ХХК мөн биз дээ, илтгэлд ХКУ олон улсын стандартын гэрчилгээ авсан гэж байна, махмпэкс дээр авч болдоггүй юм уу?махмпэкс гэсэн үндсэн үйлдвэр дээрээ авсан бол их сайн байх байлаа, гэхдээ энэ бол чамлахааргүй амжилт, цаашаа "хасаф" нэвтрүүлэх үү?

З.Ичинноров: хасафыг нэвтрүүлэхийн төлөө ажиллана, бид олон улсын стандартын гэрчилгээ авахын тулд бүхэл бүтэн баг бүтэн жил ажилласаны үр дүн.

Хувьцаа эзэмшигч Туул : Хурлын хэлэлцэх асуудлыг хувьцаа эзэмшигчдээсээ санал хүсэлтийг нь авч гаргаж баймаар байна,бид хөрөнгөө компанид оруулсан учир бидний санал хүсэлтийг тусгаач, 2015 оны ногдол ашиг үнэхээр бага байна,биднийг олон удаа хуурч чадахгүй шүү,бид чинь бас юм ойлгодог хүмүүс шүү.хэзээ ч алдагдалтай ажиллана гэж байхгүй. Хувьцаа Эзэмшигчдийн хурал дээр гүйцэтгэх захирал нь алга, удирдлага тайлангаа тавьсангүй.Удирдлагаас уул нь асуух асуулт байсан юм.

Хурлын дарга Л.Янжин:Та бүхний үнэтэй саналыг бид сонслоо,хурлын тэмдэглэлд тусгагдаж байгаа,хойшид бид ажилдаа тусгаж ажиллах болно, та бүгдэд баярлалаа.Санал, шүүмжлэлээ таслах уу гэхэд бүгд зөвшөөрлөө.

Баярлалаа, та бүхэнд, өөр санал, хүсэлт байхгүй бол тооллогын комисс санал хураалтын дүн гаргатал түр завсарлая.

22

Үүний дараа тооллогын комиссын дарга Н.Болортуяа “ Саналын хуудсыг тоолж, дүнг хуралд танилцуулах тухай ” тогтоолыг уншиж танилцуулав. / уг тогтоолыг хурлын материалын -р хуудсанд хавсаргав./

Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит Хуралд 377 ширхэг саналын хуудас буюу 2161254 ширхэг хувьцааны санал иржээ. Хуралд ирүүлсэн саналын хуудсыг нэг бүрчлэн шалгаж үзэхэд 377 ширхэг саналын хуудсыг буюу 2161254 ширхэг хувьцааны санал хүчинтэйд тооцов.

. Хурлаар хэлэлцсэн асуудал тус бүр дээр тоолж үзвэл:

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны тайланг батлахыг зөвшөөрсөн 2158783.ширхэг хувьцаа буюу нийт саналын 99.88 %, татгалзсан 588 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0.027%, түдгэлзсэн 804 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0.037 % байна.

2. Компанийн 2014 оны санхүүгийн үйл ажиллагааны тайланг батлахыг зөвшөөрсөн 2158484 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99.87 %, татгалзсан 729 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0,003 %, түдгэлзсэн 443 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0.02 % байна.

3. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр:

* Ж.Чинзоригийг сонгохыг зөвшөөрсөн 2158309 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99.86 %, татгалзсан 1061 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0.049 %, түдгэлзсэн 451 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0.02 % байна.

*Ж.Баттөрийг сонгохыг зөвшөөрсөн 2155148 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99.71%, татгалзсан 4149 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0,19%, түдгэлзсэн 289 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0.0013% байна.

*Д.Цэнддоржийг сонгохыг зөвшөөрсөн 215269 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99.72%, татгалзсан 4149 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0.013% байна.

*Л.Янжинг сонгохыг зөвшөөрсөн 215517 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99.73 %, татгалзсан 3902 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0.18 %, түдгэлзсэн 216 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0.012 % байна.

*Х.Цэндбаярыг сонгохыг зөвшөөрсөн 2154995 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99.71 %, татгалзсан 4366 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0.20 %, түдгэлзсэн 316 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0.014% байна.

*Д.Жанчивдоржийг сонгохыг зөвшөөрсөн 2157187 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99.81%, татгалзсан 1863 ширхэг хувьцаа нийт саналын 0.086 %, түдгэлзсэн 679 ширхэг хувьцаа нийт саналын 0.031% байна.

4. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр :

* М.Баттогтохыг сонгохыг зөвшөөрсөн 2154262 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99.67.%, татгалзсан 2933 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0,13 %, түдгэлзсэн 883 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0.04% байна.

*Н.Лхачинбалыг сонгохыг зөвшөөрсөн 2156063 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99.75 %, татгалзсан 2333 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0.10%, түдгэлзсэн 696 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0.032% байна.

*Ц.Цолмонг сонгохыг зөвшөөрсөн 2154202 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99,67%, татгалзсан 2459 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0,11%, түдгэлзсэн 1451 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0,067% байна.

4. Компанийн 2015 оны ТУЗ-ийн төсвийг 14.460.000 төгрөгөөр батлахыг зөвшөөрсөн 2156786 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99,79%, татгалзсан 1679 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0,077%, түдгэлзсэн 848 ширхэг буюу нийт саналын 0,039% байна.

5.. Ногдол ашиг хуваариалахыг зөвшөөрсөн 2157049 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99,8%, татгалзсан 707 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0,032%, түдгэлзсэн 1474 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0,068% байна.

гэж танилцууллаа.

Үүний дараа тооллогын комиссын дүнг үндэслэн Хувьцаа Эзэмшигчдийн Хурлаас :

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ –өөс өгсөн дүгнэлтийг зүйтэй гэж үзсүгэй.

2. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр:

*Ж.Чинзоригийг 99.86% ийн саналаар

*Ж.Баттөрийг 99.71% ийн саналаар

*Д.Цэнддоржийг 99.72% ийн саналаар

*Л.Янжинг 99.73% ийн саналаар

*Х.Цэндбаярыг 99.71% ийн саналаар

*Д.Жанчивдоржийг 99.81% ийн саналаар тус тус сонгосугай.

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр:

*М.Баттогтохыг 99.67% ийн саналаар

*Н.Лхачинбалыг 99.75% ийн саналаар

*Ц.Цолмонг 99,67% ийн саналаар тус тус сонгосугай.

3. 2015 оны ТУЗ-ийн төсвийг 14.460.000 төгрөгөөр баталсугай.

4. Ногдол ашгийг 100₮-өөр тогтоосугай

гэсэн тогтоолыг гаргаж танилцуулахад хувьцаа эзэмшигчид 100% санал нэгтэй батлав.

Үүгээр хурлын ажиллагаа 16 цаг 10 минутад өндөрлөв.

Хурлын дарга:

Тэмдэглэсэн:



Л.Янжин

И.Өлзийбаяр